



**НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ
АЛБАНЫ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2024.01.10

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /НТОЗШША/-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан "Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

НТОЗШША-ны 2023 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 2 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **84%**-тай үнэлэгдсэн.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. НТОЗШША-ны 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Үнэлээгүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
19	8	5	3	2	-	-	1	86,7%

НТОЗШША нь 2023 онд 19 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт 19 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 8 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 5 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 3 арга хэмжээ, 50%-ийн биелэлттэй 2 арга хэмжээ, үнэлээгүй 1 арга хэмжээ, хэрэгжилт дунджаар 86,7%-тай байна.

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

№	Арга хэмжээний заалт, агуулга	Хүрэх түвшин	Ирүүлсэн биелэлт	Тасарсан шалтгаан нөхцөл
1	4.2. Албаны гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааны	Тухай бүр: Шинжлэн шалгах ажиллагаанд тухай бүр хамтарч ажиллана, шинжээчдийн үр	Шинжлэн шалгах ажиллагааны хүрээнд Франц улсын Шинжлэн шалгах байгууллага, БНХАУ дахь Аэробусын төлөөлөгчийн газар, ИКАО-ын Ази, Номхон далайн орнуудын Шинжлэн	-Санхүүжилт -Удирдлага зохион байгуулалт



ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ

	асуудлыг зохион байгуулах.	чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг авч, туршлага солилцон, гадаад хамтын ажиллагааг сайжруулсан байна.	шалгах байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл солилцож байна. {Конвенийн 13-р Хавсралтад заасны дагуу агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн үед тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгч, эзэмшигч, зохион бүтээгч, хөдөлгүүрийн үйлдвэрлэгч, эзэмшигч орнуудтай харилцан мэдээлэл солилцож, техникийн дүгнэлт хийн, шинжлэн шалгах ажиллагаа явуулж байна. НТОЗШША-ны 2023 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг гарган батлуулсан. Санхүүгийн байдлаас шалтгаалан төлөвлөсөн сургалт, уулзалт семинараас хэрэгжсэн арга хэмжээ байхгүй байна. 2024 оны төсөвт дахин тусгуулахаар өгсөн. 50%	
2	4.3.НТОЗШША-ны дүрэмд өөрчлөлт оруулж, батлуулах.	1 дүгээр улиралд: Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулна. 2 дугаар улиралд: Нэмэлт өөрчлөлтийг ЗТХ-ийн сайдын тушаалаар батлуулсан байна.	Албаны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулахаар ЗТХЯ-д хүргүүлээд байна. 2023.02.03-ны 09/23 тоот албан бичгээр хүргүүлсэн. ЗТХС-ын тушаал гараагүй. Хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан албаны дүрэмд дахин нэмэлт өөрчлөлт оруулж байна. Албаны бие даасан үйл ажиллагаа явуулах үйл ажиллагааны талаар хуулийн хэрэгжилт хойшлогдсон байна. 70%	Гадаад хүчин зүйл
3	5.2. Шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай багаж тоног, төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл зэргийн нөөцийг бүрдүүлж, байнгын бэлэн байдалд байлгах.	1 дүгээр улиралд: Иж бүрдэл, хэрэгсэл, төхөөрөмжийн судалгааг гаргана. 2 дугаар улиралд: Нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай төсөв, тооцоог гаргасан байна. 3, 4 дүгээр улиралд: Нормын дагуу бэлтгэж, бэлэн байдалд байлгана. Шаардлагатай төсвийг 2024 оны төсөвт тусгана.	Шинжлэн шалгах ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмжийн жагсаалт, шинжээчдийн хувцас хэрэглэлийн судалгааг шинээр гаргаж, бэлтгэх ажлыг хийв. Тоног төхөөрөмжид /зөөврийн компьютер, CVR-ийн интерфейс кабель, мэдээлэл татагч, тэжээлийн блок/ 13300000 төгрөг, 6 шинжээчийн хэрэг, ослын газарт, хээрийн нөхцөлд өмсөх нормын хувцас, хөдөлмөр хамгааллын хэрэглэлд /Тусгай зориулалтын ажлын өмд, цамц, комбинезон, хамгаалалтын малгай, маск, хэрэглэл: саравчтай нарны малгай, ажлын бээлий, резинен ба дулаан бээлий, чихний хамгаалалт/ 3990000 төгрөг шаардлагатай гэсэн судалгаа гарсан.	- Удирдлага, зохион байгуулалт

			<p>2024 оны төсөвт хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн хамгаалах хэрэгсэл, нормын хувцасны төсвийг гаргаж, 2023 оны 6 сард ИНЕГ-т хүргүүлсэн. ХАБЭА-н ажилтныг шинээр томилон, холбогдох журмыг шинэчлэн, төлөвлөгөөний дагуу биелэлтийг гарган ажиллаж байна. 70%</p>	
4	<p>7.2. Шинжлэн шалгах ажиллагаанд дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх, инновацын судалгаа хийх</p>	<p>Хагас жилийн байдлаар: 1, 2 дугаар улиралд: Ажлын цар хүрээгээ тогтоож, судалгаа хийх ажлын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж эхэлсэн байна.</p>	<p>Албаны үндсэн чиг үүрэг осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд ашиглах агаарын хөлгийн нислэгийн өгөгдөл болон яриа бичлэгийн төхөөрөмжийн /FDR/CVR/ бичлэгийг тайлж унших ажиллагааг сайжруулах зорилгоор</p> <ol style="list-style-type: none"> 1. Шинэ програм хангамж, 2. Тоног төхөөрөмж, техник хэрэгслүүдийг судалж, нэвтрүүлэх ажиллагаа хийгдэж байна. <p>Канад улсын Planescenes компанийн шинэ технологи болох FAV-INV шинэ системийн талаарх судалгаа хийсэн. АНУ-ын Honeywell, L3-Com-ын тоног төхөөрөмжүүдээс худалдан авахаар судалгаа хийв. Цаашид нислэгийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, шинжлэн шалгах ажиллагаанд нэвтрүүлэх зорилт тавиад байна.</p> <p>Санхүүгийн асуудлаас болж шинэ програм хангамж, төхөөрөмж худалдан авах ажиллагаа сүүлийн 3 жил шийдэгдэлгүй хойшлогдож байгаа тул нэмэлт судалгаа хийн, хаана өөр технологи гарч нэвтрүүлж байгааг судалж байна.</p> <p>ИНЕГ-аас хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж тендер зарлан худалдан авах шийдвэр гарсан. Тендерийн материал болон техникийн үзүүлэлтүүдийг гарган бүрдүүлж өгсөн. ИНЕГ-ээс уг төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг хассан тул дараа жилийн төсөвт оруулахаар болов. 50%</p>	<p>- Санхүүжилт шийдэгдэхгүй удааширсан</p>
5	<p>7.3. Цахимжуулсан үйлчилгээ, үйл ажиллагааны</p>	<p>Тухай бүр: Цахимжуулсан үйлчилгээ, үйл ажиллагааныхаа</p>	<p>Албаны талаарх мэдээлэл, үйл ажиллагааны талаар цахим хуудсаар ил тод тайлагнадаг. Агаарын хөлгийн осол, ноцтой</p>	<p>- Удирдлага, зохион байгуулалт</p>

	<p>талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулах.</p>	<p>талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулсан байна.</p>	<p>зөрчлийг шинжлэн шалгасан тайлан, дүн шинжилгээ, дүгнэлт, аюулгүй ажиллагааны зөвлөмжүүдийг он, оноор нь гарган тухай бүр байршуулдаг. Цахим хуудсандаа шинэчлэлт хийж бүх өгөгдөл, мэдээллийг дахин байршуулсан. Албан ёсны болон сайн дурын мэдээлэл өгөх бүх арга хэмжээг цахимаар авах бололцоог бүрдүүлэн 24 цагийн мэдээлэл авах утас ажиллуулж, жижүүр шинжээчид томилон ээлжээр ажиллаж байна. Албаны үйл ажиллагааг ил тод сурталчлан, мэдээллийн самбар болон зурагт хуудас хэвлэн холбогдох байгууллагууд, нисэх компаниудад тараадаг, нэрийн хуудастаа мэдээлэл, авах, өгөх бүх арга зам, хаяг, утас зэргийг багтаасан байдаг. Мэдээлэл өөрчлөгдсөн тухай бүрд өөрчлөлтийг оруулан хүргүүлж байна. 70%</p>
--	---	--	---

2.2. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
Нийт	12	9	-	2	1	-	80,0

Хэрэгжилт хангалтгүй:

- 1/ Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт – 0%
- 2/ Ажлын байрны сул орон тооны талаар мэдээлэл – 30%
- 3/ Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ – 30%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

НТОЗШША нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, яамны БТГ-аар хянуулан баталгаажуулсан байна.

НТОЗШША-аас Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.3, 3.4, 3.5-д заасан “Нисэх буудлууд, агаарын тээврийн байгууллагуудын үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийх, Иргэний нисэхийн хяналт зохицуулалтын үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийх” ажлуудыг НТОЗШША-ны чиг үүрэгт хамаарахгүй, ИНЕГ болон харьяа байгууллагууд хийх ажил тул гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс хасч, эсвэл шинжлэн шалгах ажиллагааны хүрээнд явагдаж буй судалгаа, шинжилгээний ажлуудыг тооцон дүгнүүлэх санал ирүүлсэн.

ХШҮДАГ нь Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ баталсан төлөвлөгөө, урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-



шинжилгээ, үнэлгээ хийдэг тул дээрх ажлыг дур мэдэн хасч дүгнэх боломжгүй, мөн шинжлэн шалгах ажиллагааг явуулж, тайлан, дүгнэлт гаргах ажил гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусдаа заалт болж орсон тул энэхүү ажиллагааны хүрээнд явагдаж буй судалгаа, шинжилгээний ажлуудыг орлуулан тооцож дүгнэх үндэслэлгүй байна.

2. Хэрэгжилтийн байдал:

- 1) НТОЗШША-ны 2023 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 2 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **84%** буюу эхний хагас жилээс 4,6%-тар өссөн дүнтэй байна.
- 2) НТОЗШША-наас гаргасан зөвлөмжүүдээс хэрэгжээгүй үлдсэн 8 зөвлөмжийн хэрэгжилтийг 11 сарын байдлаар дүгнэн тайланг ирүүлсэн бөгөөд 100% хэрэгжсэн-5, 30%-ийн хэрэгжилттэй-3, нийт 73,7%-тай байна.
- 3) 2021 онд шинжлэн шалгах ажиллагааны 5 эцсийн тайлан, 1 урьдчилсан тайлан, 2022 онд шинжлэн шалгах ажиллагааны 2 урьдчилсан тайлан, 1 эцсийн тайлан гаргаж ажилласан бол 2023 онд 1 урьдчилсан тайлан гаргасан байна.
Өөрөөр хэлбэл 2022 онд бүртгэгдсэн осол, зөрчлийн тоо нь өмнөх оноос нэмэгдсэн /2021 онд 24 зөрчил, 2022 онд 1 осол, 32 зөрчил, 2023 онд 35 зөрчил бүртгэгдсэн/ боловч хийсэн шинжлэн шалгах ажиллагааны тайлангийн тоо буурсан байна.
- 4) 2022 оны жилийн эцэс, 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжүүдийн дагуу дараах ажлууд хийсэн байна. Үүнд:
 - 2023 оны төлөвлөгөөнд тогтмол хийдэг ажлуудаас гадна тус албаны дүрэмд заасан “Нислэгийн аюулгүй ажиллагааг сайжруулах зорилгоор судалгаа, шинжилгээ хийн дүгнэлт гаргах”, “Агаарын тээврийн 1-2 байгууллагыг сонгон үйл ажиллагаанд нь судалгаа, шинжилгээ дүгнэлт гаргах” зэрэг ажлыг нэмж тусган хэрэгжүүлсэн;
 - Ахлах шинжээчийн ажлын хэрэгцээнд тоон гарын үсгийн хэрэглээг нэмж, 1 токен төхөөрөмж захиалан гэрээ байгуулан баталгаажуулж, ашиглалтад оруулсан байна.
 - Албаны цахим хуудсыг “Дата Центр”-ийн сервер дээр байрлуулах, цахим хуудсанд орох мэдээ, мэдээлэл, ашиглах зарчим, шаардлагатай үзүүлэлт зэргийг англи, монгол хэл дээр бэлтгэж, өгөгдлийг дахин шинээр оруулж, засварлах ажил хийсэн.
 - Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг шинэчлэн баталсан журмын дагуу дүгнэн тайланг улирал бүр Зам, тээврийн хөгжлийн яаманд ирүүлсэн;
- 5) 2022 онд НТОЗШША-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжүүдээс дараах зөвлөмжүүд хэрэгжихгүй удааширсан хэвээр байна. Үүнд:
 - Сул байгаа оронд тоонд албан тушаалын тодорхойлолтод тавигдсан шаардлагыг бүрэн хангасан хүнийг сонгон шалгаруулах замаар сул орон

тоог яаралтай нөхөх, албан тушаалтан, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэшүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах;

- Тоон гарын үсгийг албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд туссан арга хэмжээний зардал, шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай багаж тоног, төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийн зардлыг 2024 оны төсөвт тусган батлуулж, хэрэгжүүлэн ажиллах;
2. Шинжлэн шалгасан осол, зөрчлийн тайлан удаашралтай, тайлангийн тоо өмнөх онуудаас буурч байгаад анхаарч ажлын зохион байгуулалтыг сайжруулах, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхой тусгах;
3. Сул байгаа оронд тоонд албан тушаалын тодорхойлолтод тавигдсан шаардлагыг бүрэн хангасан хүнийг сонгон шалгаруулах замаар сул орон тоог яаралтай нөхөх, албан тушаалтан, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэшүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах;
4. Тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх, Ил тод нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдээс байгууллагын цахим хуудсанд тавиагүй мэдээллүүдийг 1 сард багтаан мэдээлэх,

ТАНИЛЦСАН:

САЙД



С.БЯМБАЦОГТ

ДЭД САЙД



Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



С.БАТБОЛД

ИНБЗГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОДХҮҮ

НТОЗШША-НЫ ДАРГА



Ж.ЦОЛМОН

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГА



А.МӨНХБАТ

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН ШИНЖЭЭЧ



Д.БАЯРМАА



**НТОЗШША-НЫ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

№	Хяналтанд байх арга хэмжээ	2023 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Биелэлт /Хувиар/							Хугацаа болоогүй	Үнэлээгүй
				Дундаж хувь	100	90	70	50	30	0		
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	19	18	86.7	8	5	3	2	-	-	-	1
2	Ил тод нээлттэй байдлын үнэлгээ	12	12	80.0	9	-	-	-	2	1	-	-
Нийт		31	30	84.0	17	5	3	2	2	1	-	1